

Газрын зургийн нэг маягийн суурь гэж юу вэ?

Газрын зураг зохиоход тухайн сэдэвчилсэн зурагт дүрслэх шаардлагатай элемент, объектуудыг хэлбэр, хэмжээ, агуулгаар нь тодорхойлж дүрсэлснийг нэг маягийн суурь гэнэ.

Улсын геодези, зураг зүйн газар УГЗЗГ (хуучнаар) 1:1 000 000, 1:2 500 000, 1:3 000 000, 1:5 000 000, 1:10 000 000, 1:12 000 000, 1:13 000 000-ны масштабын нэг маягийн сууриуд **позитив** байдлаар хийсэн байдаг.

(Улсын геодезийн солбицлын тогтолцоонд хийсэн)



2015-2017 онд тус газраас 1:1 000 000, 1:1 500 000, 1:2 000 000, 1:2 500 000, 1:3 000 000, 1:5 000 000, 1:6 000 000, 1:9 000 000, 1:10 000 000, 1:12 000 000, нийтдээ 10 төрлийн масштаб бүхий нэг маягийн суурь зохиож, нийтэд түгээх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

(2009 оны ЗГ-ын 25-р тогтоол Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолоонд хийсэн)

Газрын зургийн нэг маягийн суурь зохиож, түгээх ажил


Ажил хэрэгжиж байгаа байдал	2015-2017 он	2017-2018 он
Нэг маягийн суурийг зохиож, түгээх /масштабаар/	1:1 000 000	
	1:6 000 000	
	1:9 000 000	
	1:12 000 000	
		1:500 000
		1:1 500 000
		1:2 500 000
		1:3 000 000
		1:5 000 000

Газрын зургийн нэг маягийн сууриар бүх төрлийн газрын зурагт нийтлэг дүрслэгддэг газар зүйн элементүүдийг масштаб бүрээр дүрслэх хэлбэр, хэмжээг стандарчлан тодорхойлдог. Үүнд:


1. Аймаг, сум, нийслэл, дүүргийн баталгаажсан хил
2. Суурин газрууд
3. Авто болон төмөр зам
4. Ус зүйн элементүүд
5. Газрын гадаргын элемент

6. Газар зүйн нэр


1:1 000 000 масштаб бүхий нэг маягийн суурь




1:6 000 000 масштаб бүхий нэг маягийн суурь



1:9 000 000 масштаб бүхий нэг маягийн суурь



1:12 000 000 масштаб бүхий нэг маягийн суурь



Эдгээр 1:1 000 000, 1:6 000 000, 1:9 000 000, 1:12 000 000 масштаб бүхий нэг маягийн сууриуд нь **тоон** болон

позитив хэлбэрээр ГЗБГЗЗГ-ын Геодези, байр зүйн зургийн мэдээллийн санд хадгалагдаж байна.

Хууль, эрх зүйн орчин

Монгол улсын Геодези, зураг зүйн тухай хуулинд:

4.1. Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд дараах ажил хамаарна:

4.1.3. төрөл бүрийн масштабтай тусгай зориулалт бүхий сэдэвчилсэн, сургалтын болон нийтийн хэрэгцээний газрын зураг зохиох, шинэчлэн хэвлэх;
5.5. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нууцын зэрэглэлтэй материал үйлдвэрлэж, хадгалж байдгийн хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн тусгай хамгаалалтад байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:


5.5.9. төрөл бүрийн масштабтай байр зүйн болон дэвсгэр зургийг олгох, худалдах, шилжүүлэх, мэдээллээр хангах; (Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг)

Ач холбогдол

- ❖ Газрын зургаар дамжуулан аливаа юмс үзэгдлийн байршил, хэмжээ, мөн чанар, хөгжил хөдөлгөөн зэргийг зураг зүйн дүрслэлийн аргуудын тусламжтайгаар хэрэглэгчдэд хүргэх үндэс суурь болдог;
- ❖ Баталгаажсан нэг маягийн суурийг олон нийтэд түгээснээр янз бүрийн хэлбэр хэмжээ, гажилттай газрын зураг хэрэглэхийг зогсоох боломж бүрдэнэ;


Газрын зургийн нэг маягийн суурь байхгүйгээс гарч буй хүндрэл

- ❖ Монгол улсын газрын зургийн хэлбэр хэмжээ алдаатай, буруу дүрсэгдэх;
- ❖ Хүүхэд багачууд, залуучуудад буруу ойлголт өгч, танин мэдэхүйд муугаар нөлөөлөх;
- ❖ Гажилттай газрын зургийг олон нийтэд хүргэснээр хэрэглэгчид төөрөгдөлд орох;



Газрын зургийн хэрэглээ
Орчин үед байгууллага, иргэд өөрийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг:

❖ Газрын зураг



❖ Атлас



❖ Ном, зохиол



❖ Тайлан



❖ Тэмдэглэлийн дэвтэр



❖ Бэлэг, зүйлс



дурсгалын

❖ Зарсурталчилгааг интернетээр



газрын зураг ашиглан нийтэд түгээж байна.

Төрийн болон төрийн бус байгууллага, ААН, иргэн нь төрөл бүрийн газрын зураг, атлас зохиох, ном, зохиол, тэмдэглэлийн дэвтэр хэвлэх, тайлангийн зураг бэлдэх, бэлэг дурсгалын зүйл хийх, зар сурталчилгаа хийх зэрэгт газрын зураг ашиглахдаа нэг маягийн суурийг тус газраас заавалавч ашиглах шаардлагатайг анхаарна уу.

Монгол улсын Геодези, зураг зүйн тухай хуулинд:

12.1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэн геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдсон дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

12.1.4. зохих хууль тогтоомжид заасан журмыг зөрчин байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хийсэн зураг зүйн бүтээлийг хуулбарлах, олшруулах, хэвлэх.

14.3. Энэ хуулийн 12.1.4-т заасныг зөрчсөн этгээдэд Зохиогчийн эрхийн тухай болон Патентын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Факс: 976-11-329638

И-мэйл: info@gazar.gov.mn

Цахим хаяг: <http://www.gazar.gov.mn/>



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

ГАЗРЫН ЗУРГИЙН НЭГ МАЯГИЙН СУУРЬ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Барилгачдын талбай-3, Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын XII байр
Утас: 976-11-329638

2017 он